



2012 оны 2 дугаар
сарын 12 ны өдөр

Дугаар А/10-115

Утас: 321844, 329430, 70110744

Факс: 976-11-321844

Шуудан: “Mongol Post” LLC

Имэйл хаяг: ubaudit_corp@mongol.net

Вебсайт: www.ulaanbaatar-audit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН “МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд

Бид “Монголиа Девелопмент Ресорсес” ХК-ийн (цаашид “компани” гэх) 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан болон уг өдрөөр дуусгавар болсон дэлгэрэнгүй орлогын, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, бусад нэмэлт тодотголуудаас бүрдсэн (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Энэхүү санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, үүнтэй холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагууд орно.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт, Монгол улсын “Аудитын тухай” хуулийн дагуу гүйцэтгэв. Энэхүү стандартаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэдэг үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн талаар аудитын нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажлууд багтах болно. Сонгон авах горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж болох эрсдэлийн үнэлгээг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна.

Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс компанийн санхүүгийн тайланг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Мөн аудитын ажилд удирдлагын хийсэн томоохон тооцооллууд болон баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг үнэлэх ажлууд багтана.

Бидний хийж гүйцэтгэсэн аудит нь энэхүү гаргасан дүгнэлтэнд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

“МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС” ХК

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, “Монголиа Девелопмент Ресорсес” ХК-ийн санхүүгийн тайлан нь 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаархи санхүүгийн байдлын тайлан болон уг өдрөөр дуусгавар болсон дэлгэрэнгүй орлогын, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан, бусад нэмэлт тодотголууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хүндэтгэсэн,
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.ОСОРГАРАВ.

(Монгол Улсын гавъяат эдийн засагч,
Монгол Улсын шилдэг нягтлан бодогч,
Монгол Улсын шилдэг менежер,
Монгол Улсын шилдэг маркетер)

“МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС” ХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(мянган төгрөгөөр)

	Тодотгол	2011.12.31	2010.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Дуусаагүй барилга	3	1,106,323.6	876,050.5
Үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж (цэвэр)	4	1,621,949.8	1,787,951.6
Биет бус хөрөнгө (цэвэр)	5	1,532.9	2,584.7
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	6	7,679,438.0	3,399,091.7
Нийт эргэлтийн бус хөрөнгийн дүн		10,409,244.3	6,065,678.5
Эргэлтийн хөрөнгө			
Урьдчилж төлсөн тооцоо/зардал		-	16,756.2
Бараа материал	7	129,794.8	128,045.0
Авлага	8	2,441,362.4	3,524,435.9
Богино хугацаат хөрөнгө оруулалт	9	4,354,692.9	5,592,462.6
Мөнгөн хөрөнгө	10	187,157.0	962,291.6
Нийт эргэлтийн хөрөнгийн дүн		7,113,007.1	10,223,991.3
НИЙТ ХӨРӨНГӨ		17,522,251.4	16,289,669.8
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Эзэмшигчийн өмч			
Хувьцаат капитал	11	13,750,000.0	13,750,000.0
Халаасны хувьцаа		(5,658.0)	(5,658.0)
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		1,742,777.5	528,732.9
Нийт эзэмшигчийн өмчийн дүн		15,487,119.5	14,273,074.9
Өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөр	12	1,968,184.2	1,914,590.6
Богино хугацаат өр төлбөр	13	66,947.7	102,004.4
Нийт өр төлбөрийн дүн		2,035,131.9	2,016,595.0
НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		17,522,251.4	16,289,669.8

Нэмэлт тодотголууд нь энэхүү санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

“МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС” ХК

ОРЛОГЫН ТАЙЛАН

2011 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

(мянган төгрөгөөр)

	Тодотгол	2011.12.31	2010.12.31
Орлого	14	2,632,495.2	1,463,190.2
Өртөг	15	(1,859,060.6)	(1,075,298.0)
Нийт ашиг (алдагдал)		773,434.6	387,892.2
Бусад орлого	16	1,901,432.6	2,057,144.5
Ерөнхий удирдлагын зардал	17	(1,019,057.6)	(1,170,336.0)
Үйл ажиллагааны ашиг (алдагдал)		1,655,809.6	1,274,700.7
Хүүгийн зардал		(269,099.8)	(85,440.9)
Бусад зардал		(99,108.6)	(82,880.2)
Татварын өмнөх ашиг (алдагдал)		1,287,601.2	1,106,379.6
Орлогын татварын зардал	18	(107,573.0)	(102,004.4)
Тайлант жилийн татварын дараах цэвэр ашиг (алдагдал)		1,180,028.2	1,004,375.2
Хувьцааны жинлэсэн дундаж тоо		13,747.6	13,747.6
Нэгж хувьцаанд ногдох ашиг		167.2	73.1

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн нэг саллигүй хэсэг болно.

“МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС” ХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2011 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Өмчийн дүн
2009 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	12,958,057.6	301,727.1	13,259,784.7
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	791,942.4	(791,942.4)	-
Залруулсан үлдэгдэл	13,750,000.0	(490,215.3)	13,259,784.7
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	14,573.00	14,573.0
Буцааж татсан хувьцаат капитал	(5,658.0)	-	(5,658.0)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	1,004,375.2	1,004,375.2
2010 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	13,744,342.0	528,732.9	14,273,074.9
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	34,016.4	34,016.4
Буцааж татсан хувьцаат капитал	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	1,180,028.2	1,180,028.2
2011 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	13,744,342.0	1,742,777.5	15,487,119.5

Нэмэлт тодотголдууд нь эдгээр санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

“МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС” ХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2011 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

	(мянган төгрөгөөр)	
	2011.12.31	2010.12.31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	248,123.8	47,958.3
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	248,123.8	47,958.3
Туслах үйл ажиллагаанаас орсон мөнгө		-
Бусад мөнгөн орлого		-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	(2,754,074.1)	(3,788,183.2)
Ажилчдад олгосон мөнгө	(323,360.9)	(319,039.5)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	(36,699.3)	(52,985.4)
Хангамжийн материалд төлсөн мөнгө	(30,364.2)	(11,326.2)
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	(1,863.5)	(2,885.1)
Түлш, шатахуун, тээврийн хэрэгсэлд төлсөн мөнгө	(48,401.4)	(53,612.7)
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгө	(1,837,522.4)	(3,188,510.4)
Төлсөн хүү	(269,099.8)	(59,144.6)
Төлсөн татвар	(123,681.3)	(52,604.0)
Бусад	(83,081.3)	(48,075.3)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,505,950.3)	(3,740,224.9)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого	5,100.0	359.0
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	(287,610.3)	(2,078,833.6)
Хийгдсэн хөрөнгө оруулалт	-	(2,953,536.0)
Хөрөнгө оруулалтаас орж ирсэн	2,130,871.8	1,821,525.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	1,848,361.5	(3,210,485.6)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Банкнаас авсан зээл	-	4,313,559.0
Зээлийн төлөлт	(144,321.9)	(2,340,040.2)
Мөнгөөр эргүүлж худалдан авсан хувьцаа	-	(5,658.0)
Хүү ба урамшууллын орлого	34,595.3	276,081.7
Гадаад валютын ханшийн зөрүү	2,180.8	(11,281.7)
Ногдол ашгийн орлого	-	2,128.5
Бусад	(10,000.0)	(34,920.2)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(117,545.8)	2,199,869.1
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(775,134.6)	(4,750,841.4)
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	962,291.6	5,713,133.0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	187,157.0	962,291.6

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.